



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/202

Мөрөн сум

Иргэний газар өмчлөх эрхийг дуусгавар
болгож, гэр бүлийн гишүүнд өмчлүүлэх
тухай газрын байршил, талбайн хэмжээнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 5 дугаар зүйлийн 5.1.4, 7 дугаар зүйлийн 7.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 31 дүгээр зүйлийн 31.1.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өмчийн газраа бусад гэр бүлийн иргэний өмчлөлд шилжүүлэх өргөдөл гаргасан нэр бүхий 3 иргэний газар өмчлөх эрхийг дуусгавар болгож, 1 иргэнд тухайн газрыг өмчлүүлж нийт 531м² газарт кадастрын мэдээллийн санд байгаа талбай хэмжээ, байршлаар нь өөрчлөлт оруулж хавсралт ёсоор баталсугай.


2. Хувийн хэргийн бүрдүүлэлтийг ханган, өмчилсөн газрыг улсын бүртгэлд бүртгэж мэдээллийн санд өөрчлөлтийг тусган захиргааны актыг оролцогчдод мэдэгдэхийг Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-д эрхийн баталгаанд өөрчлөлт хийхийг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус даалгасугай.

3. Аймгийн Засаг даргын энэхүү шийдвэрийг оролцогчид эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Газар өмчлөгчийн үүргийн биелэлтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Мөрөн сумын Засаг дарга (Д.Идэрмөнх)-д даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6712010050

Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын
01-ний өдрийн А/2022... дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХИЙН БАЙРШИЛ, ТАЛБАЙН ХЭМЖЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ӨМЧЛүүлсэн жагсаалт

№	Захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болгох		Өмчлөгчийн			Цуцалсан өмчлөгчийн		Шинээр өмчлөгч ийн	Өмчилсөн газрын өөрчлөлт		Нэгж талбарын дугаар	Тайлбар
	Огноо дугаар	Хавсралт ын мөр баганыг дугаар	Ургийн овог	Овог нэр /регистр/	Газрын байрши л /хаяг/	Өмчилсөн газрын хэмжээ /м2/	Овог, эцэг /эх/- ийн нэр, өөрийн нэр	Регистр	Овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн өөрийн	Кадастры н зурагт байгаа хэмжээ	Үнэ /мян.т өг/	Гэр бүлийн гишүүнд өмчлүүлж, газрын хэмжээг кадастрын зургийн дагуу өөрчилсөн
0	1	2	3	4	5	6	8	9	10	11	12	14
1	2005.12.2 6 №264	8 дахь мөр	Цогнууд	Баасанжа в Энхболд РЭ591216 13	5.7.12	400	С.Наранццэг Э.Ууганбаяр Э.Уянга	РЮ64122768 РЮ85081761 РЭ89100666	Баасанжа в Энхболд РЭ591216 13	531	1593	6712002864

Нийт талбай 531м2

Handwritten signature